



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Сүхбаатар аймгийн Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан,  
тодруулгад хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СБА-2026/002/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Баруун-Урт хот  
2026 он

Дарга,  
тэргүүлэх аудитор: Г.Даваа  
Утас: 70518396  
Аудитын менежер: М.Нарантуяа  
Утас: 70512123  
Ахлах аудитор: Ө.Золзаяа  
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....</b>	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....</b>	<b>8</b>
<b>4.1 Ерөнхий зүйл .....</b>	<b>10</b>
<b>4.2 Материаллаг байдал.....</b>	<b>11</b>
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....</b>	<b>11</b>
<b>4.5.1 Завсрын аудитын талаар .....</b>	<b>11</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....</b>	<b>12</b>
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>	<b>12</b>
<b>5.1 Албан шаардлага.....</b>	<b>12</b>
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>	<b>13</b>

**Товчилсон үгийн жагсаалт**

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

6 давхарт, Нутгийн удирдлагын 2 дугаар байр,  
Балдан-Осорын гудамж, 7 дугаар баг,  
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22075  
Утас: (976) 70518396  
Цахим шуудан: sukhbaatar@audit.gov.mn

2026.03.15 № 202

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлого үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 18 тоот тогтоолоор “Хайлааст голомт” ОНӨААТҮГ-ын цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг баталсан байна.

#### Аудитын гол асуудал

Хайлааст голомт ОНӨААТҮГ 2025 оны санхүүгийн тайлангаар 90.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан бөгөөд цаашид зардлыг оновчтой удирдаж, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх замаар ашигтай ажиллах шаардлагатай байна.

D:\Бичиг хэрэг\2026\Явсан бичиг\A4 тоот.docx

2226050109

### **Бусад асуудал**

Хайлааст голомт ОНӨААТҮГ-ын 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлуулж, онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, тодруулга нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
А	Б	1	2
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8,860,850.34	1,217,293.85
1.1.1.2	Банкин дахь мөнгө	8,860,850.34	1,217,293.85
1.1.2	Дансны авлага	25,994,299.07	36,764,748.86
1.1.2.2	Борлуулалтын авлага	25,994,299.07	36,764,748.86
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	3,601,443.00	387,244.50
1.1.3.1	НӨАТ-ын тооцоо	45,455.01	387,244.50
1.1.3.2	Орлогын татварын тооцоо	3,555,987.99	-
1.1.3.6	ЭМНД-ийн шимтгэлийн тооцоо	-	0.00
1.1.4	Бусад авлага	14,538,962.55	13,286,597.46
1.1.4.1	Хувь хүнээс авах авлага	9,552,181.09	9,577,525.00
1.1.4.2	Байгууллагаас авах авлага	4,986,781.46	3,709,072.46
1.1.6	Бараа материал	11,607,084.85	42,178,302.95
1.1.6.1	Түүхий эд материал	8,674,366.04	18,293,254.13
1.1.6.4	Хангамжын материал	1,573,250.27	22,525,580.27
1.1.6.5	Сэлбэг хэрэгсэл	1,359,468.55	1,359,468.55
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	84,259.02	84,259.02
1.1.7.1	Урьдчилж төлсөн зардал	84,259.02	84,259.02
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>64,686,898.84</b>	<b>93,918,446.63</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,127,106,638.62	3,037,030,272.54
1.2.1.2	Барилга байгууламж	2,821,325,578.00	2,811,680,628.00
1.2.1.3	Хуримтлагдсан элэгдэл. Барилга	(203,424,837.80)	(419,461,036.28)
1.2.1.4	Машин, тоног төхөөрөмж	642,261,765.81	876,299,015.81
1.2.1.5	Хуримтлагдсан элэгдэл. МТТ	(325,265,443.32)	(398,707,625.92)
1.2.1.6	Тээврийн хэрэгсэл	193,000,000.00	177,500,000.00
1.2.1.7	Хуримтлагдсан элэгдэл. Тээвэр	(60,062,499.96)	(67,112,499.96)
1.2.1.8	Тавилга эд хогшил	67,423,566.82	63,992,767.09
1.2.1.9	Хуримтлагдсан элэгдэл. ТЭХ	(10,632,587.60)	(9,929,158.09)
1.2.1.10	Компьютер, бусад хэрэгсэл	11,712,316.27	3,222,727.27
1.2.1.11	Хуримтлагдсан элэгдэл. Компьютер	(9,231,219.60)	(454,545.38)
1.2.2	Биет бус хөрөнгө	21,179,200.00	21,179,200.00
1.2.2.3	Компьютер Програм хангамж	500,000.00	500,000.00
1.2.2.4	Хуримтлагдсан элэгдэл. Програм хангамж	(500,000.00)	(500,000.00)
1.2.2.13	Бусад биет бус хөрөнгө	21,179,200.00	21,179,200.00
1.2.1	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>3,148,285,838.62</b>	<b>3,058,209,472.54</b>
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,212,972,737.46</b>	<b>3,152,127,919.18</b>
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,762,210,436.58	2,788,768,215.30
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	30,592,623.77	34,133,399.77
2.1.1.1.1	Байгууллагад өгөх өглөг	30,592,623.77	34,133,399.77
2.1.1.13	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,792,803,060.35</b>	<b>2,822,901,615.07</b>
2.1.2.10	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,792,803,060.35</b>	<b>2,822,901,615.07</b>
2.3.1	Төрийн өмч	559,377,218.00	559,377,218.00

2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	50,346,312.00	50,346,312.00
2.3.6.1	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ	50,346,312.00	50,346,312.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг:	(189,553,852.89)	(280,497,225.89)
2.3.9.1	Тайлант үеийн ашиг	-	(90,943,373.01)
2.3.9.2	Өмнөх үеийн ашиг	(189,553,852.89)	(189,553,852.89)
2.3.11	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>420,169,677.11</b>	<b>329,226,304.11</b>
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,212,972,737.46</b>	<b>3,152,127,919.18</b>

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	<b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>	<b>431,887,117.3</b>	<b>456,156,378.3</b>
1.1	Бараа бүтээгдэхүүн борлуулсны орлого	431,887,117.3	456,156,378.3
2	<b>Борлуулалтын өртөг</b>	<b>428,647,516.4</b>	<b>431,038,136.5</b>
2.1	Борлуулсан бараа, бүтээгдэхүүний өртөг	428,647,516.4	431,038,136.5
3	<b>Нийт ашиг /алдагдал/</b>	<b>3,239,601.0</b>	<b>25,118,241.9</b>
4	Түрээсийн орлого	15,366.7	-
8	Бусад орлого	183,389,806.3	208,139,597.8
9	Борлуулалт, маркетингийн зардал		23,797,011.8
10	Ерөнхий ба удирдлагын зардал	119,736,988.5	300,404,200.9
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(25,992,337.3)</b>	<b>(90,943,373.0)</b>
19	Орлогын татварын зардал	1,536.7	-
-	Тайлангийн үеийн орлогын татварын зардал	1,536.7	-
20	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(25,992,337.3)</b>	<b>(90,943,373.0)</b>
22	<b>Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>(25,992,337.3)</b>	<b>(90,943,373.0)</b>
24	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(25,992,337.26)</b>	<b>(25,992,337.26)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	ЗГ-ын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.0	50,346,312.0	(163,559,978.9)	446,163,551.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	(25,993,873.9)	(25,993,873.9)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	559,377,218.0	50,346,312.0	(189,553,852.9)	420,169,677.1
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	559,377,218.0	50,346,312.0	(189,553,852.9)	420,169,677.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	559,377,218.0	50,346,312.0	(189,553,852.9)	420,169,677.1
19	Тайлант үеийн үр дүн	0	0	(90,943,373.0)	(90,943,373.0)
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	559,377,218.0	50,346,312.0	(280,497,225.9)	329,226,304.1

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>467,391,611.88</b>	<b>491,163,665.33</b>
	1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	491,154,095.06

	1.1.6 Бусад мөнгөн орлого	9,725,000.00	9,570.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	479,031,857.40	454,399,409.82
	1.2.1 Ажилчдад төлсөн	156,242,514.00	184,742,202.00
	1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	52,532,150.46	62,944,937.07
	1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	111,629,196.00	49,530,863.00
	1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	57,124,807.12	73,731,767.34
	1.2.5 Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	15,541,922.00	15,601,410.00
	1.2.6 Хүүний төлбөрт төлсөн	-	6,410,192.03
	1.2.7 Татварын байгууллагад төлсөн	65,590,031.76	49,318,260.38
	1.2.8 Бусад мөнгөн зарлага	20,371,236.01	12,119,778.00
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(1,915,245.52)</b>	36,764,255.51
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	13,830.06	1,727,709.00
	2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	1,727,709.00
	2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	13,830.06	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,300,000.00	-
	2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	3,300,000.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(3,286,169.94)</b>	1,727,709.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	<b>46,135,521.00</b>
	3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	46,135,521.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	-	<b>(46,135,521.00)</b>
4.1	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(5,201,415.41)</b>	(7,643,556.49)
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>14,062,265.75</b>	8,860,850.34
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,860,850.34</b>	1,217,293.85

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2024 оны Гүйцэтгэл	2025 оны төлөвлөгөө	2025 оны Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	гкал	3.95	2.63	2.63
2	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн тоо		81.00	81	81
	-айл өрхийн тоо	ш	57.00	57	57
	-Албан байгууллагын тоо	ш	24.00	24	24
3	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн үнэ	төг	1,623.00	1,368.00	1,368.00
4	Нийт орлого	мян.төг	594,667.90	492,678.70	456,156.30
	цэвэр борлуулалт	мян.төг	431,887.10	456,344.00	431,038.10
5	Нийт зардал	мян.төг	620,661.70	500,496.00	500,496.00
	Үүнээс: удирдлагын зардал	мян.төг	192,011.30	300,404.20	300,404.20
6	Татварын өмнөх ашиг	мян.төг	(25,993.80)	-9,185.80	-90,943.30
7	Цэвэр ашиг (алдагдал)	мян.төг	(25,992.30)	-9,185.80	-90,943.30
8	Төсвийн төлбөр		2,420.00	2,420.00	2,420.00
9	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	мян.төг	1.00	0.98	0.98
10	Нийт авлага	мян.төг	44,089.00	93,918.00	93,918.00
11	Нийт өглөг	мян.төг	30,592.60	36,764.00	36,764.00
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	30,592.60	36,764.00	36,764.00
12	Хөрөнгө оруулалт, их засвар ТЗБАХ	мян.төг	137,000.00		
13	Ажиллагсадын тоо	мян.төг	15.00	15	15

14	Цалингийн сан	мян.төг	156,242.50	174,912.70	174,912.70
15	Нийт хөрөнгийн дүн	мян.төг	3,212,972.70	3,205,936.40	3,212,972.00
16	-эргэлтийн хөрөнгө	мян.төг	64,686.80	90,175.40	93,918.00
	үүнээс бараа материал	мян.төг	11,607.00	38,247.70	42,178.00
17	-үндсэн хөрөнгө	мян.төг	3,127,106.60	3,094,581.70	3,037,030.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын зорилго нь тус сумын хэрэглэгчдийг дулаанаар хангах, унд ахуйн чанар стандартад тохирсон усыг олборлон түгээх, хэрэглээний явцад гарсан бохир ус, хог хаягдлыг татан зайлуулах ажлыг хэвийн явуулах” зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Сүхбаатар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны А/03 дугаар тогтоолоор байгууллагын дүрэмд өөрчлөлт оруулж, тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Дулаан үйлдвэрлэл, сумын төвийн албан байгууллага, аж ахуй нэгжийн байр, иргэдийн сууцыг нийтийн цэвэр усаар хангах, цэвэрлэх байгууламжийн үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх болон дулаанаар хангах бөгөөд өмчийн 100 хувийг орон нутаг эзэмшиж байна.

#### 3.2 Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар 2.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих...” гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.10-т “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно.” гэж заасан байна. Энэ хүрээнд бүртгэлийг сайжруулж анхан шатны бүх худалдан авалтыг сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалыг хэрэгжүүлэн НӨАТ-ын баримтыг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас бүрэн авч ажиллажээ.

Дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог 15 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 15 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 1,804.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй гэж дүгнэлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Хайлааст голомт ОНӨААТҮГ -ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,024.0 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,860.9	1,217.3	(7,643.6)
Авлага	44,134.7	50,438.6	6,303.9
Бараа материал	11,607.1	42,178.3	30,571.2
Үндсэн хөрөнгө	3,148,285.8	3,037,030.3	(111,255.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,212,888.4</b>	<b>3,130,864.5</b>	<b>(82,024.0)</b>
Урьдчилж орсон орлого	2,762,210.4	2,788,768.2	26,557.8
Өр төлбөр	30,592.6	34,133.4	3,540.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	559,377.2	559,377.2	-
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,212,888.4</b>	<b>3,130,864.5</b>	<b>(82,024.0)</b>

Харилцахын үлдэгдэл 1,217.3 мянган төгрөг болж 7,643.6 мянган төгрөгөөр буурсан нь Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн баталсан жишиг цалин хөлстэй уялдуулан албан хаагч нарын цалинг нэмэгдүүлсэн, мөн зарим үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалтай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 50,438.6 мянган төгрөг болж өмнөх оноос 6,303.9 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны авлагыг барагдуулж ажиллаагүй, тайлант онд шинээр авлага бий болсон байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 41,178.3 мянган төгрөг болж өмнөх оноос 30,571.2 мянган төгрөгөөр өссөн байна. Үүнд түлш шатахууны данс буюу нүүрсний үлдэгдэл нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,037,030.3 мянган төгрөг болж өмнөх оноос 111,255.5 мянган төгрөгөөр буурсан нь холбогдох байгууллагын шийдвэрээр 33,710.4 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлээс хасаж акталсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 34,133.4 мянган төгрөг болж 3,540.8 мянган төгрөгөөр өссөнд тээвэр, түлш шатахууны зардал нөлөөлсөн байна.

### **3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Хайлааст голомт ОНӨААТҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь 2025 онд Сүхбаатар сумын Засаг даргатай гэрээ байгуулан ажиллажээ.

Тус байгууллага 2025 онд зорилтот түвшин, үйл ажиллагааны төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалт, бусад эх үүсвэрийг зохих шатны байгууллагад хүргүүлж батлуулжээ.

Тайлант оны нийт орлогыг 492,678.7 мянган төгрөгөөр, нийт зардлыг 500,496.7 мянган төгрөгөөр, 9,182.8 мянган төгрөгийн алдагдалтай баталжээ.

### **Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин**

Гүйцэтгэлээр 456,156.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 500,496.0 мянган төгрөгийн зардал гарган, 90,943.3 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Энэ нь айл өрх, төсвийн болон аж ахуйн нэгж байгууллагын халаалт дулааны төлбөрийн орлогын бүрэн төвлөрүүлээгүй, өмнөх онд үүссэн авлагыг барагдуулж ажиллаагүй, цалин хөлсийг Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс баталсан жишиг цалинтай уялдуулан нэмсэн нь нөлөөлжээ.

Нийт орлогын гүйцэтгэл 456,156.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 35,522.4 мянган төгрөг буюу 7.4 хувиар буурсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 500,496.0 мянган төгрөг буюу төлөвлөснөөс илүү, дутуу зарцуулалт гаргаагүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хайлааст Голомт ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн ААТҮГ-ийн үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ө.Золзаяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Нарантуяа, дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа нар тус тус хэрэгжүүлсэн.

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 3 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлаас 548,384.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,225.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант оны өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан тушаал шийдвэрийг мэдээлжээ.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь бусад хууль тогтоомжийн хүрээнд асуудал гараагүй.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хайлааст голомт ОНӨААТҮГ нь завсрын аудит хийж эд хөрөнгийн тооллогыг хуулийн дагуу чанартай хийж гүйцэтгэх талаар зөвлөмж хүргүүлсэн.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар олон жилийн насжилттай авлага өглөгийг барагдуулж ажиллах, аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй 1, албан үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчид хариуцлага тооцуулах 1 нийт 2 албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитын шийдвэрийн биелэлт 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	2	-	2		100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>2</b>		<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нүүрс тээврийн хөлс, нүүрсний зарцуулалт болон цэвэр бохир усанд холбогдсон байгууллагын орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг нарийвчилж үзэхээр төлөвлөв.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар олон жилийн насжилттай авлагыг барагдуулж ажиллах 1 албан шаардлага, өмнөх оны аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг хүргүүллээ.

#### 5.1 Төлбөрийн акт

Сүхбаатар сумын Засаг даргын 2025 оны 1 дүгээр сарын Б/06 дугаар захирамжаар захирал Б.Хүрэл-Очирт халаалтын инженерийн албан үүргийг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдлийг 40 хуваарь бодож олгохоор шийдвэрлэсэн боловч захирлын албан тушаалын цалингийн 30 хувиар тооцсоноос цалин хөлсийг 619.4 мянган төгрөгөөр дутуу бодож олгосон. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 (Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.), 13.6 (Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.), 20 дугаар зүйлийн 20.2.5 (дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах) дахь заалттай тус тус нийцэхгүй байна.

#### 5.2 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, тодруулгад илэрхийлсэн 2,245.5 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5/дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/ заалттай нийцэхгүй байна.

#### 5.3 Зөвлөмж

##### 1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалыг улирлын нийт дүнгээр орлого авч, зарлагадсан нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан маягтын дагуу бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг тухайн цаг хугацаанд хөтлөх, батламж мэдэгдлийн хүрээнд толилуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Цалин дутуу олгосон	1	619.4	1	619.4	-	-	-	-		
Тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	2,245.5	-	-	1	2,245.5	-	-		
БМ тайланг стандартын дагуу гаргаагүй	1	-	-	-	-	-	1	-		
<b>ДҮН</b>	<b>3</b>	<b>2,864.9</b>	<b>1</b>	<b>619.4</b>	<b>1</b>	<b>2,245.5</b>	<b>1</b>	<b>-</b>		